



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
УЛААН-УУЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 05 сарын 07 өдөр

Дугаар А/56

Төгөл

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.3, 46 дугаар зүйлийн 46.1.1, 46.1.6 дэх заалт, Иргэний хуулийн 343-358 дугаар зүйл, Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2024 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн 02 дугаар албан даалгаврыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2024 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн 02 дугаар албан даалгавар бүхий, Орчны бохирдол, хуулийн хэрэгжилтийг хангах, эрчимжүүлж албан даалгаврын хүрээнд Тус сумын хогийн цэгийг танаж багасгах, нүх ухаж, дарж, булах ажил хийх 35,000,000 (гучин таван сая) төгрөг төсөвт өртөг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Дарга:

М.Отгонбаатар /зөвшилцсөнөөр/ (Засаг даргын орлогч)

Т.Амарсайхан (Төгөл багийн Засаг дарга)

Ш.Нямаа (Тамгын газрын Галч, Манаач)

Л.Санжаа (Төгөл 5-р багийн иргэн)

Нарийн бичгийн дарга: Г.Батчимэг (Байгаль орчны мэргэжилтэн)

2. Холбогдох хууль тогтоомж, дүрэм журмыг чанд мөрдөн зохион байгуулж ажиллахыг ажлын хэсгийн дарга (М.Отгонбаатар)-т үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавин ажиллахыг Худалдан авах ажиллагаа хариуцсан ажилтан (Г.Шинэбаяр)-т үүрэг болгосугай.

ДАРГА Г. ШИНЭБАЯР



/Zahiramj/